

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2021.11.22

Цагаандэлгэр сум

№	Зорилт, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин (Тайланг: 2000 тэмдэгтэд багтаан бичих, зарцуулсан хөрөнгийн хэмжээ бичих, тайлангийн хэрэгжилтийн хувь тайланд тусгах)	Хэрэгжилтийн хувь
					Он	Түвшин			
2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
2.1. Эрүүл мэнд									
2.1.3.1	Арга хэмжээ: Нэгдсэн эмнэлгийг компьютер томографи, сумдыг мобайль технологийн хангана.	2021-2024	72.0	Мобайль технологийн хангагдсан сумын тоо	2019	4	8	2021 онд нийт Mobile Dermatology-аппликейшинг ашиглан нийт 12 иргэнийг оношлон эмчилсэн. 2021 оны 9 сард аймгийн Эрүүл мэндийн газраас олгосон хяналтын монитормыг ашиглан эрчимт эмчилгээнд хэрэглэж байна.	70
2.3 . Боловсрол									
2.3.1.1	Арга хэмжээ: Сайнцагаан, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Адаацаг, Хулд, Цагаандэлгэр суманд шинээр цэцэрлэгийн барилга барих	2021-2024	1000.0	Ашиглалтад шинээр орсон цэцэрлэгийн тоо	2020	2	3	100 хүүхдийн шинэ цэцэрлэгийн барилгын ажлыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын дагуу “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу 2022 оны төсвийн төсөлд тусгахаар төслийн шинжилгээ, тооцооллыг аймгийн БСУГ-аар дамжуулан Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст материалыг албан тоотоор цаасаар болон файлаар хүргүүлсэн.	30
2.4. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал									
2.4.2.3	Арга хэмжээ: Хөдөлмөр эрхлэх төсөлд 180 иргэнийг нэмж хамруулан, байнгын ажлын байртай болгох	2021-2024	-	Төслийн үр дүнд бий болсон ажлын байрны тоо	2019	173	193	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас 2021 онд 5 төрлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Төслийн талаарх мэдээллийг сумын цахим группүүдэд байршуулах мөн иргэдтэй биечлэн уулзах хэлбэрээр хүргэсэн. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төсөл 6 сараас эхлэн улсын хэмжээнд зарлагдсан. Сумын хэмжээнд тус төсөлд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 1	50

								иргэн, ажил эрхэлдэггүй 1 иргэн бүртгүүлсэн. Эрүүл мэндийн шалтгааны улмаас төсөлд хамрагдаж чадаагүй.	
2.5 Үндэсний бахархал, өв соёл									
2.5.1.4	<u>Арга хэмжээ:</u> Сумдын Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, Цагаандэлгэр, Өлзийт, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Баянжаргалан, Өндөршил, Адаацаг, Гурвансайхан, Дэлгэрхангай сумдын Соёлын төвийн барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах	2021-2024	2913.0	Тухайн жилд ашиглалтад орсон Соёлын төвийн тоо	2020	0	4	Цагаандэлгэр суман дахь 240 хүний суудалтай соёлын төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Хэрмээдэй” ХХК ажиллаж байна. Одоогоор 1, 2 давхрын дүүргэлт хийгдэж барилгын ажил 48%-ын гүйцэтгэлтэй явж байна. 	50
2.5.3.6	<u>Арга хэмжээ:</u> Сумдын түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг сумын гэрээт хамгаалагчтай болгох	2021-2024	75.6	Сумдын гэрээт хамгаалагчдын тоо	2020	0	15	Түүх, соёлын, үл хөдлөх дурсгалт газар 2020 онд 38 байснаас 2021 онд шинээр 2 газар илрүүлж нийт 40 дурсгалт газар бүртгэсэн байна. Дурсгалт газрын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор 2020 онд 13 газрыг 12 малчинтай гэрээ хийж хамгаалалтанд авсан бол энэ онд шинээр 27 газрыг 16 малчинтай гэрээ хийж хамгаалалтанд авлаа. Хамгаалалтанд авснаар ухагдаж хөндөгдсөн булш, хиргисүүр байхгүй болно. Сумын хэмжээнд нийт 40 дурсгалт газар, 28 гэрээт хамгаалагчид байна.	90

									
3. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО									
3.1 Санхүү, төсвийн зохицуулалт									
3.1.2	<u>Зорилт:</u> Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгож, худалдан авалтанд орон нутгийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь 2020 онд 30 байсныг 2024 онд 40 хувьд хүргэнэ.	2021-2024	4.8	Орон нутгийн ААН-ийн эзлэх хувь	2020	30	35	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй зарлан мэдээлж танилцуулсан. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр зарлагдсан 3 ажлаас 2 ажлыг нутгийн 2 бүлэг хийж гүйцэтгэсэн. “Итгэл дүүрэн” бүлэг ЕБС-ийн сургуулийн багш нарын байрны засварыг 9.831.000, “Түмэн залаат” бүлэг 2-р багийн төв барих 19.000.000 төгрөгийн төсвөөр хийж гүйцэтгэсэн байна.	90
3.1.2.1	<u>Арга хэмжээ:</u> Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймгийн вэбсайт болон пейж хуудсаар тухай бүр мэдээлэх	2021-2024	-	Нийт зарлагдсан тендерээс вэбсайт болон пейж хуудсанд урилга, үр дүнг нийтэлсэн тендерийн эзлэх хувь	2020	70	100	Гэрээ шууд байгуулах аргаар 3 тендер зарласан. Тендерийн урилгыг цахим хуудсанд байршуулж 3-аас дээш компанид урилга хүргүүлэн тухай бүр мэдээлсэн.	90
3.1.2.2	<u>Арга хэмжээ:</u> Төрийн худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийг чадавхижуулах	2021-2024	4.8	АЗ сертификаттай иргэдийн нөөц бүрдүүлэх сургалтын тоо	2019	2	2	АЗ сертификаттай иргэдийн нөөц бүрдүүлэхээр 1 удаагийн сургалтанд 4 албан хаагчийг хамруулсан.	70

		2021-2024		АЗ сертификат эзэмшигчийн иргэдийн тоо	2020	97	120	Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтанд 4 иргэнийг хамруулсан. Шалгалт зарлагдаагүй байна.	30
4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба									
4.2	<u>Зорилго:</u> Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил 2020 онд 10 хувьтай байсныг 2024 онд 4 хувиар бууруулна.	2021-2024	83.2	сахилга, ёс зүйн хариуцлага зөрчлийн бууралт	2019	10	9	ЗДТГ-аас 17 төрийн албан хаагчидтай 2021.01.14-нд ёс зүй, хариуцлагын гэрээ байгуулсан. 1 албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан. Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр ЗДТГ-ын дотоод сургалтын төлөвлөгөөг баталж 9 удаагийн сургалт зохион байгуулж 15 албан хаагчийг хамруулсан байна. Мөн 2021.10.28-нд төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтнууд болон төрийн захиргааны албан хаагчдын дунд “Төрийн албан хаагчийн манлайлал” уулзалт, ярилцлагыг зохион байгуулж Рояль ОУИС-ын төрийн удирдлагын хөтөлбөрийн удирдагч, доктор Б.Байгалмаа лекц зохион байгуулж, ЕБС-ийн захирал, МУГБагш Д.Октябрь “Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага” сэдвээр сургалт зохион байгуулж 31 албан хаагч хамрагдлаа.  ЕБС-аас багш, ажилчидтай 2021.01.05-нд ёс зүйн гэрээг байгуулан сахилга, ёс зүйн доголдол, зөрчилгүй ажиллаж байна. НТБ-ын үндэсний	90


								төвөөс зохион байгуулсан “Ёс зүйн боловсрол” олгох 3 хоногийн цахим сургалтанд НТБ-ын багш Н.Оюунцэцэг хамрагдан сургуулийн нийт 22 багш, ажилтанд “Ёс зүйн хариуцлага” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. ЭМТ-ийн 15 албан хаагчидтай гэрээ байгуулан эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ сэдвээр 2 удаагийн сургалтыг ёс зүйн багаас зохион байгуулсан. Соёлын төвөөс 6 албан хаагчидтай “Ёс зүй, сахилга хариуцлага”-ын гэрээг байгуулж “Төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүй”-н чиглэлээр дотоод сургалтыг 1 удаа 4 албан хаагчдад зохион байгуулж, сахилга ёс зөрчилгүй ажиллаж байна. Хүүхдийн цэцэрлэгээс албан хаагч нарын дунд ёс зүйн дүрэм, байгууллагын соёл, хүүхэд хамгааллын дүрэм журмыг танилцуулах сургалтыг 3 удаа зохион байгуулж албан хаагчдыг ёс зүйн дүрэмтэй танилцуулж, гарын үсгээр баталгаажуулах зэрэг ажлуудыг зохион байгуулснаар 2021 онд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна.	
4.2.1	<u>Зорилт:</u> Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэн томилгооны зөрчлийг 2020 онд 33.2 хувь байсныг 2024 онд 13.3 хувиар бууруулна.	2021-2024	30.0	томилгооны зөрчлийн бууралт	2020	33.2	23.3	2021 онд тус суманд дутагдалтай байгаа 16 боловсон хүчний нэгдсэн судалгааг /дутагдалтай ажлын байр/ гаргаж аймгийн сайт, мэдээллийн самбар болон цахим орчинд байршуулсан. Үүнээс хөдөлмөрийн хугацаатай /түр/ болон хугацаагүй гэрээ байгуулан 11 орон тоог нөхөж ажилласан байна. 2021 оны 10 сард зохион байгуулагдсан төрийн албаны тусгай шалгалтанд 1 албан хаагч тэнцэж томилгооны зөрчилгүй болсон байна. Дутагдалтай боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор	70

								сумын оюутны нэгдсэн судалгааг гаргаж төгсөх курсын оюутнуудтай холбогдож орон нутагтаа ирж ажиллах саналыг хүргэж ажиллалаа.	
4.2.1.1	<u>Арга хэмжээ:</u> Улс төрөөс хараат бус, чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцсэн мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлэх	2021-2024	5.0	Шатлан дэвшсэн төрийн албан хаагчдын хувь	2020	10	15	Төрийн захиргааны 1 сул орон тоон дээр шатлан дэвших зарчмын дагуу 1 албан хаагчийг дэвшүүлэн томилон ажиллуулж байна. Тус албан хаагч төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтуудыг өгч тэнцэн томилгооны зөрчилгүй ажиллаж байна.	90
4.2.1.2	<u>Арга хэмжээ:</u> Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулах	2021-2024	83.2	Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	2020	46	92	ЗДТГ-аас 68 удаагийн богино хугацааны /цахим, танхим/ сургалтанд 16 албан хаагчийг хамруулсан. Боловсролын зэрэг ахиулах сургалтанд 1 албан хаагч суралцаж төгссөн байна. ЕБС-аас шинээр томилогдсон болон бусад албан хаагчдыг богино болон урт хугацааны сургалтуудад бүрэн хамрууллаа. Тухайлбал: - Мэргэжлийн багш нар өөрсдийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд цахимаар давхардсан тоогоор 16 удаагийн сургалтанд хамрагдаад байна. - “Гүрэн академи”-ийн сургалтанд бага ангийн багш У.Мөнх-Эрдэнэ, -2021.08.25-27 ЕБС-ийн сурагчидын хичээл сургалтыг нөхөх, арилгах, төлөвлөгөөг хэрэгжүүлж саргалтын үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр нийт багш удирдлагууд /19 хүн багш/, - Хосолсон сургалтын арга зүйд дэмжлэг үзүүлэх сургалтанд сургалтын менежер, дунд ангийн багш 1, бага ангийн багш 1, - Англи орос хэлний багш нарын сургалтанд багш А.Эрдэнэсайхан	90

							- Дотуур байрын багш Г.Жигдиймаа цахимаар 3 удаа байрын багш нарын сургалтанд 9,10,11 саруудад хамрагдсан. - НТБҮТ, Монгол банк, АТГ, Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт, АЗДТГ зэрэг дээд байгууллагаас зохион байгуулсан 12 удаагийн цахим сургалтанд НТБ-ын багш тус тус хамрагдсан. Соёлын төвөөс 2021 онд улс, аймаг бүсээс зохион байгуулсан 5 сургалтанд 5 албан хаагч, сум орон нутгаас зохион байгуулсан 7 сургалт мэдээлэлд 6 албан хаагч, байгууллагын дотоод 3 сургалтанд 5 албан хаагч бүрэн хамрагдсан байна.   Цэцэрлэгээс шинээр ажилд орсон 2 албан хаагчийг сумын НТБ-ын багш Н.Оюунцэцэгийн зохион байгуулсан “Шинэ ажилтан чиглүүлэх” сургалт, БМДИ-ийн үндсэн сургалтанд анхны жилдээ ажиллаж буй багш Э.Мэнд-Амарыг тус тус хамруулснаар албан хаагч нар мэргэжил арга зүйн чиглэлтэй, ажлын төлөвлөгөө боловсруулах болон бусад албан бичгийг боловсруулах чадварт суралцсан. ЭМТ-ийн сувилагч Г.Буянжаргал, Б.Мөнхтамир нар ковид-19-ын вакцины хадгалалт, тээвэрлэлт, тарих техникийн талаарх 2 хоногийн цахим сургалтанд хамрагдсан. Их эмч Б.Баярбаатар аймгийн ЭМГ-аас	
--	--	--	--	--	--	--	---	--

								зохион байгуулсан МОНПЭН төслийн хүрээнд Коронавирусаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах сургалтанд 2 удаа, нягтлан бодогч Д.Түмэн-Өлзий нь цалингийн нэгдсэн систем, хүний нөөцийн сургалтанд тус тус хамрагдсан.	
4.2.2.1	<u>Арга хэмжээ:</u> Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтийн оролцоотой хамтран хэрэгжүүлэх.	2021-2024	10.0	Авлигаас урьдчилан сэргийлэх тухайн жилийн төлөвлөгөөн ий хэрэгжилт	2019	80	85	Цагаандэлгэр сумын ЗДТГ-ын 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2021.02.22-ны өдөр сумын Засаг даргаар батлуулан байгууллага, албан хаагчдад хүргүүлж танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Багийн хурал, олон нийтийг хамарсан үйл ажиллагааны үеэр иргэд болон малчдыг “Дундговь авлигагүй хөгжинө” уриалгад нэгдүүлж, гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаар танилцуулж цахим хуудсаар дамжуулан авлигаас урьдчилан сэргийлэх мэдээллийг 5 удаа байршуулж, иргэд олон нийтэд мэдээллийг хүргүүлсэн.  Нийтийн албан тушаалтны хамаарал бүхий этгээдийн судалгааг гарган цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж мэдээлсэн.	90

								Авлигаас урьдчилан сэргийлэх сэдэвт гарын авлага боловсруулан мэдээллийн самбарт байршуулан 65 иргэнд сурталчилгааны материал тараасан. Авлигын эсрэг олон улсын өдрийг угтаж сум, байгууллагын удирдлагууд, багийн Засаг дарга нар "ДУНДГОВЬ АВЛИГАГҮЙ ХӨГЖИНӨ" уриалгад нэгдлээ. 	
4.2.2.2	<u>Арга хэмжээ:</u> Сум, байгууллагын эрх бүхий албан тушаалтан(ЭБАТ)-уудыг жил бүр чадавхжуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах.	2021-2024	2.5	ЭБАТ-ны сургалт, семинарт хамралтын хувь	2019	80	90	Тус сумын ИТХ, ЗДТГ-ын ЭБАТ-ууд 2017 оноос хойш тогтвор суурьшилтай ажиллаж байна. Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс 2020 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны бэлтгэл хангах, мөн нийт ЭБАТ-уудад мэдээлэл хүргэх сургалтыг 2021 оны 2 сарын 08-ны өдөр зохион байгуулсан ба уг сургалтанд сумын 2 ЭБАТ бүрэн хамрагдсан. Мөн АЗДТГ-ын ЭБАТ-аас тухай бүр заавар зөвлөгөө авч ажиллаж байна.	90

4.2.3.1	Арга хэмжээ: Иргэд, олон нийтэд чиглэсэн нэгдсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ сургалт, сурталчилгааг жил бүр 3-аас доошгүй сумдад зохион байгуулах	2021-2024	3.0	тухайн жилд хууль зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулсан сумдын тоо	2019	2	3	Эрх зүйн хөтөч багаас 2021 онд байгууллага, албан хаагчидтай хамтран судлан сурталчлах хууль эрх зүйн актын нэгдсэн төлөвлөгөөг батлуулж 60 эрх зүйн актын талаар мэдээлэл өгөх, сурталчлахаар төлөвлөснөөс 3-р дугаар улирлын байдлаар танхимаар 3, цахимаар 17 удаагийн хууль, эрх зүйн сургалт мэдээллийг төрийн байгууллагын нийт 75 албан хаагчдад хүргэсэн. Иргэд олон нийтэд цахим сүлжээгээр хууль эрх зүйн мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна. 1-р багийн хөдөөгийн 17 малчин иргэдэд эрх зүйн богцыг аялуулсан байна. 	90
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ									73.7